



**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР, БУЛГАН АЙМГИЙН
БҮРЭГХАНГАЙ СУМДЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ
“ИХ ТОХОЙРОЛ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН.**

/Тусгай зөвшөөрлийн дугаар **MV-007712, MV-021704/**
/Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар № **5722942/**

Хянасан: БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, Байгалийн нөөцийн удирдлагын газрын
ахлах шинжээч.....Ц.Жаргалнэмэх.

Биелэлтийг тайлагнасан: “БҮРДЭЛ МАЙНИНГ” ХХК-ийн
Гүйцэтгэх захиралУ.Угтах.

Байгаль орчны ажилтан:.....Д.Хуягбаатар.

АГУУЛГА.

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн нэр.....	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага.....	3
1.3. Төслийн байршил.....	3-5
1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц.....	5
1.5. Уурхайн дэд бүтэц.....	5-8
1.5.1. Уурхайн барилга байгууламж.....	5-7
1.5.2. Цахилгаан хангамж.....	7
1.5.3. Усан хангамж.....	7
1.5.4. Зам харилцаа.....	8
1.6. Уурхайн хүчин чадал болон ажиллах хугацаа.....	8-9
1.7. Баяжуулах технологи.....	9
1.8. 2022 оны Уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга.....	9-10
2. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	10
2.1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	10
2.2. Газрын гадарга, хэвлий, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	10
2.3. Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	10-11
2.4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	11
2.5. Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	11
2.6. Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөлөл.....	11
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	12
3.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй.....	12-13
3.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	13-24
1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	10
2. Гадаргын болон газрын доорх ус, түүнд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	15-19
3. Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	19-22
4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	22
5. Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	22-24

6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	24
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	24-31
4.1 Биологийн нөхөн сэргээлт.....	25-28
4.2. Техникийн нөхөн сэргээлт.....	29-31
5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	31-36
5.1 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.....	31-32
5.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдсэн ажил.....	33-36
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	37
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	37
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	38-39
9. ХОГ ХАЯГДЛЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	39-42
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	42-44
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	45-46
12. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАСАН БАЙДАЛ.....	47
13. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР.....	48
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ.....	49

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Их тохойрол” алтны шороон орд ашиглах төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

“Бүрдэл Майнинг” ХХК

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **9011419045**

Регистрийн дугаар: **5722942**

Бүртгүүлсэн огноо: **2013.06.19**

Хаяг: УБ хот, СБДүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын талбай-2, Централ Тауэр 12 дугаар давхар.

Утас: **77222282, 99589597**

1.3. Төслийн байршил

“Бүрдэл майнинг” ХХК нь 2016 оноос эхлэн ашигт малтмал ашиглах MV-007712, MV-007713 тусгай зөвшөөрөл бүхий “Их тохойрол” алтны шороон ордод олборлолтын үйл ажиллагааг явуулж байна.

Тус орд нь Төв аймгийн Заамар, Булган аймгийн Бүрэгхангай сумдын хилийг дамнан орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 260 км-т, Заамар сумын төвөөс баруун хойд зүгт 35 км-т, Бүрэгхангай сумын төвөөс зүүн урд зүгт 50 км-т Туул голын сав газарт байрлана.

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нийт 1910.85 га бөгөөд Бүрэгхангай сумын нутагт 884.72 га, Заамар сумын нутагт 1036.14 га талбай тус тус хамаарагддаг. 2019 онд голын онцгой хамгаалалтын бүсд хамаарах талбай, 2020 онд ашигт малтмалын нөөцгүй талбайг хасуулсан. Талбайг хэсэгчлэн буцаан өгсөнтэй холбоотойгоор MV-007712, MV-007713, MV-021704, MV-021706, MV-021707, MV-021708, MV-021710 дугаартай тусгай зөвшөөрлүүдэд хуваагдаж “Их тохойрол” нэртэй бүлэг ордын нэршлээр явж байна. Эдгээр тусгай зөвшөөрлүүдээс MV-007713, MV-021704, 021706, MV-021707, MV-021708, MV-021710 талбайд өмнөх онуудад ашиглалтын үйл ажиллагаа явагдаж дууссан ба нөхөн сэргээлт хийгдсэн, хийгдэж байгаа болно. Зөвхөн MV-007712 тусгай зөвшөөрлийн талбайд 2022 онд ашиглалтын үйл ажиллагаа явагдсан болно.



Төслийн талбайн солбицолын цэгүүдийг Хүснэгт 1-д, байршлыг Газрын зураг 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Төслийн талбайн булангын цэгийн солбицол

№	Уртраг			Өргөрөг			№	Уртраг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек		Град	Мин	Сек	Град	Мин	Сек
	1.	2.	3.	4.	5.	6.		7.	8.	9.	10.	11.	12.
MV-007712													
1.	104	27	33.08	48	20	50.75	25.	104	25	11.72	48	19	55.36
2.	104	27	33.08	48	20	22.84	26.	104	25	24.97	48	19	54.05

3.	104	27	45.28	48	20	22.84	27.	104	25	33.11	48	19	58.98
4.	104	27	45.28	48	20	14.05	28.	104	25	33.39	48	20	6.34
5.	104	28	4.77	48	20	14.05	29.	104	25	22.6	48	20	10.61
6.	104	28	4.77	48	20	1.82	30.	104	25	12.84	48	20	13.05
7.	104	26	50.95	48	20	1.82	31.	104	25	21.31	48	20	19.08
8.	104	26	50.93	48	19	36.81	32.	104	25	29.82	48	20	13.63
9.	104	25	40.94	48	19	36.81	33.	104	25	46.41	48	20	16.7
10.	104	25	40.94	48	19	6.81	34.	104	26	0.67	48	20	21.39
11.	104	24	42.94	48	19	6.81	35.	104	26	4.02	48	20	17.16
12.	104	24	47.17	48	19	19.71	36.	104	26	18.04	48	20	15.1
13.	104	24	47.47	48	19	24.98	37.	104	26	25.52	48	20	21.4
14.	104	24	47.45	48	19	35.77	38.	104	26	25.73	48	20	26.95
15.	104	24	46.92	48	19	43.45	39.	104	26	17.13	48	20	34.97
16.	104	24	44.03	48	19	49.57	40.	104	26	23.33	48	20	40.5
17.	104	24	40.03	48	19	57.83	41.	104	26	28.03	48	20	33.75
18.	104	24	36.04	48	20	2.77	42.	104	26	31.12	48	20	25.34
19.	104	24	30.37	48	20	6.21	43.	104	26	39.74	48	20	17.03
20.	104	24	30.39	48	20	8.46	44.	104	27	8.03	48	20	20.78
21.	104	24	34.65	48	20	9.75	45.	104	27	8.68	48	20	29.53
22.	104	24	45.09	48	20	8.79	46.	104	27	20.99	48	20	36.46
23.	104	24	55.06	48	20	6.09	47.	104	27	21.08	48	20	48.28
24.	104	24	59.99	48	20	0.89							
MV-021704													
№	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.	10.	11.	12.	13.
1.	104	26	8.85	48	20	32.83	21	104	24	30.24	48	19	58.73
2	104	26	17.73	48	20	22.5	22	104	24	31.22	48	19	48.1
3	104	26	12.32	48	20	19.42	23	104	24	36.68	48	19	41.81
4	104	26	4.63	48	20	25.99	24	104	24	11.93	48	19	41.81
5	104	25	56.02	48	20	26.66	25	104	24	11.93	48	19	6.81
6	104	25	44.43	48	20	22.22	26	104	23	46.94	48	19	15.81
7	104	25	39.69	48	20	24.06	27	104	23	37.94	48	19	6.81
8	104	25	34.43	48	20	28.22	28	104	23	30.94	48	19	6.81
9	104	25	15.65	48	20	22.58	29	104	23	30.94	48	20	15.17
10	104	25	4.56	48	20	13.82	30	104	24	8.26	48	20	15.17
11	104	25	7.28	48	20	8.41	31	104	24	8.26	48	20	21.61
12	104	25	24.83	48	20	4.84	32	104	24	22.41	48	20	21.61
13	104	25	26.08	48	20	1.08	33	104	24	22.41	48	20	29.48
14	104	25	16.79	48	19	59.18	34	104	24	57.18	48	20	29.48
15	104	25	9.16	48	20	6.22	35	104	24	57.18	48	20	42.41
16	104	25	0.53	48	20	9.73	36	104	25	26.62	48	20	42.41

17	104	24	48.28	48	20	13.38	37	104	25	26.62	48	20	49.52
18	104	24	33.94	48	20	14.64	38	104	26	19.83	48	20	49.79
19	104	24	24.02	48	20	10.51	39	104	26	19.86	48	20	44.22



Газрын зураг 1, 2. Их тохойрол уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн байршил

1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц

Уул уурхайн зураг төслийн “Эрдэнэс инженеринг” ХХК нь “Их тохойрол” алтны шороон ордын В-1-ээс В-23 блок хүртэлх ТЭЗҮ-ийг боловсруулсан ба АМГазрын даргын 2016 оны 08-р сарын 03-ны өдрийн т/113 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн №16-12-13 тоот дүгнэлтээр батлуулж байсан.

“Эко Алтан Заамар” ХХК-ийн олборлолтын төлөвлөгөө өөрчлөгдсөнөөр ТЭЗҮ-ний нэмэлт тодотголыг 2017 онд уул уурхайн зураг төслийн “Газар-Илч” ХХК-аар хийлгэсэн ба ордын нийт 30 блок дээр ТЭЗҮ-ний тодотголыг хийж АМГТГазрын даргын 2017 оны 09-р сарын 19-ны өдрийн т/90 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн т/17-07-04 тоот дүгнэлтээр батлуулсан.

Тус ордыг ашиглах геологийн нөөцөөс ашиглалтын хаягдал, элсний бохирдлыг тооцсоны үндсэн дээр үйлдвэрлэлийн буюу баяжуулах элсний нөөцийн хэмжээ гарна. Уг ордыг ашиглах үйлдвэрлэлийн элсний нөөцийн хэмжээ 12.4 сая.м³, дундаж агуулга 418.69 мг/м³, алтны хэмжээ химийн цэврээр 5192.89 кг байна.

1.5. Уурхайн дэд бүтэц

1.5.1. Уурхайн барилга байгууламж

Уурхайн хотхон ТЗ-н талбайн баруун хойт хэсэгт Булган аймгийн Бүрэгхангай сумын Дэрст багийн нутаг Бэрх уулын энгэрт байршина. Хотхон нь ажилчдын амьдрах байр болох контейнер сууц, гэр, уурхайн захиргааны байр, ажилчдын гал тогоо, хоолны газар, сургалтын байр, угаалгын газар, засварын газар, бараа материалын агуулах, спорт тоглоомын талбай, авто зогсоол зэргээс бүрдэнэ. Их тохойрол алтны шороон ордын уурхайд дараах барилга байгууламжууд байна. Үүнд:

- ✓ Уурхайн ажилчдын сууц (80 сууц, 120 ш гэр)

- ✓ Уурхайн оффис (40 тн-ын 10 ш контейнер)
- ✓ Гал тогоо , хоолны газар (Сэндвичин байгууламж)
- ✓ Угаалгын газар (40 тн-ын 6 ш контейнер)
- ✓ Авто засварын газар (Сэндвичин байгууламж)
- ✓ Сэлбэгийн агуулах (Сэндвичин байгууламж)
- ✓ Баяжуулах цех
- ✓ Бусад туслах материалын агуулах зэрэг орно.



Зураг 3, 4, 5, 6. Уурхайн ажилчдын хотхон.



Зураг 7, 8. Уурхайн техникийн засварын газар, сэлбэгийн агуулах.



Зураг 9, 10. Уурхайн оффис.

1.5.2. Цахилгаан хангамж

Дархан-Сэлэнгийн цахилгаан эрчим хүч дамжуулах шугамнаас 35/6 кВ-ын дэд станц байгуулж, цахилгаан эрчим хүчний хэрэгцээг ханган ажиллаж байна.



Зураг 11, 12. Дэд станц

1.5.3. Усан хангамж

Унд, ахуйн усны хэрэгцээ:

2019 онд Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт хамаарах уурхайн хотхоны хэрэгцээнд зориулан “Эрдэнэ дриллинг” ХХК-аар худаг гаргуулан ашиглаж байна. Цооног өрөмдөх зөвшөөрлийг Булган аймгийн БОАЖГазраас авч, худгуудийг усны улсын бүртгэлд хамруулан паспорт авсан. Унд ахуйн энэхүү худагт тоолуур суурьлуулсан байдаг.

Технологийн усны хэрэгцээ:

Баяжуулах үйлдвэрлэлд ашигласан усыг тунаан цэвэршүүлж эргүүлэн ашиглаж байна. Эргэлтийн усан санд карьерын шүүрлийн усыг соруулан авч сэлбэдэг бөгөөд тунгаагуурт хуримтлуулан үйлдвэрлэлд ашигладаг. Цэвэр усны нөөц хэмнэх үүднээс тунаан цэвэршүүлж дахин ашиглах усны хэмжээ 90 хувь байдаг.

1.5.4. Зам харилцаа

Их тохойрол уурхайгаас бусад сум, хот, суурин газрууд руу шороон замаар холбогддог. Ил уурхайн технологийн болон дотоод замын шимт хөрсийг тусад нь авч далан байгуулан, үйлдвэрлэлийн хаягдал болох эфель, галь зэргээр хучиж, сайжруулалт, арчилгааг тогтмол хийж байна.



Зураг 13, 14. Зассан замууд

1.6. Уурхайн хүчин чадал болон ажиллах хугацаа.

Их тохойролын алтны шороон ордод 2016 оноос ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. Ажиллах хугацаандаа ТЭЗҮ, БОННУ зэрэг үндсэн баримт бичгүүдэд үндэслэсэн тухайн жилийн Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, газар ашиглах, ус ашиглах дүгнэлт гэрээ, нийгмийн хариуцлагын гэрээ зэрэг бичиг баримтыг хуулийн дагуу бүрдүүлэн ажиллаж, тайлан, мэдээг гарган ажиллаж байна.

2022 онд уурхайн хүчин чадлыг үндсэн техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн бүтээл, уул техникийн нөхцөл зэргийг харгалзан 3 элсний нөөцийн блокийг хэсэгчилсэн байдлаар олборлон баяжуулахаар уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан.

Нийт уулын ажлын хэмжээ 4359.7 мян.м³ уулын цул шилжүүлэх буюу 4076.2 мян.м³ хөрс хуулалт хийж, 553 мг/м³ дундаж агуулгатай, 283.55 мян.м³ элс олборлож, хөрс хуулалтын дундаж итгэлцүүр 14.3 м³/м³, металл химийн цэврээр 156.971 кг олборлолтын ажил хийгдэхээр төлөвлөж ажилласан.

Олборлолт явагдах ил уурхайн нийт талбай 344.8 мян.м², Ашигт малтмалын хучаас хөрсний дундаж зузаан нь 24.6 м, элсний дундаж зузаан нь 2.63 м байна.

Элсийг 2 байршил дахь 4 ш хос үйлдвэрээр баяжуулах бөгөөд эхний байршилд 1,2 –р үйлдвэрт элсний В29 блокийн элсийг, хоёр дахь байршилд 3,4–р үйлдвэрт элсний В28, 30 блокийн элсийг тус тус угаахаар төлөвлөж ажилласан.

Уурхайд байрлан ажиллах нийт ажилчид 650 орчим хүн байх бөгөөд 3 ээлжинд хуваагдана. Ээлжийн ажиллах хугацаа уурхайд 20 хоног ажиллаж, 10 хоног амарна. 2 ээлж уурхайд ажиллаж байх хугацаанд 1 ээлж ростерийн амралтаар амарч байна. Ажиллаж байх хугацаанд 12 цагаар ажиллаж 10 хоногт нэг удаа өдөр, шөнийн ээлж солилцоно.

Хүснэгт 2 . Уурхайн нэг ээлжийн ажиллах цагийн горим

Ээлжийн цаг ашиглалтын үзүүлэлтүүд	Нэгж
Ээлж эхлэх, дуусах үзлэг	20.0 минут
Засварын хэсгийн үзлэг	10.0 минут
Цайны цаг	30.0 минут
Шөнийн завсарлага	30.0 минут
Ээлжинд зогсох нийт хугацаа	90.0 минут
Ээлжийн үргэлжлэх хугацаа	12.00 цаг
Бүтээлтэй ажиллах цаг	10.5 цаг
Нөлөөлөл тооцох коэф	87.5%

1.7. Баяжуулах технологи

Их Тохойролын алтны шороон ордод гарвитагийн аргаар баяжуулах дунд зэргийн хүчин чадалтай угаан баяжуулах үйлдвэр байхаар тооцоолсон. Үүнд алттай элсийг СБ-100 маркийн скруббер ашиглан баяжуулахаар тооцоолсон бөгөөд алт угаан баяжуулах төхөөрөмжийг сонгоход тавигдах гол шаардлага нь алтыг аль болох элснээс бүрэн гүйцэд салгаж авахад оршино.

Манай орны болон гадаадын улс орнуудын практик үйл ажиллагаанд ил аргаар олборлож байгаа алт агуулсан элсийг баяжуулахдаа үндсэн хоёр аргаар ажилладаг угаах төхөөрөмжүүдийг өргөн хэрэглэж байна. Үүнээс манай компани эргэлдэгч дамарт шигшүүрт өгөгдөх тодорхой даралттай усны үйлчлэлийн тусламжтайгаар элсийг задалж, угаан баяжуулах төхөөрөмж ба шлюзийн хослолын аргыг сонгосон байна.

1.8. 2022 оны Уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга.

Их тохойролын алтны шороон ордод 2016 оноос ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. 2022 онд үйл ажиллагаа явуулахдаа ТЭЗҮ, БОННУ зэрэг үндсэн баримт бичгүүдэд үндэслэсэн тухайн жилийн Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, газар ашиглах, ус ашиглах дүгнэлт гэрээ, нийгмийн хариуцлагын гэрээ зэрэг бичиг баримтыг хуулийн дагуу бүрдүүлэн ажиллаж, тайлан, мэдээг гарган ажилласан болно.

2022 онд 27, 28, 30 дугаар блоkd хэсэгчилсэн ашиглалтын үйл ажиллагаа явагдсан. Уурхайн бэлтгэл ажил болох техникийн засвар үйлчилгээ хийх, технологийн зам, зогсоолын талбай байгуулах, цахилгааны шугам татах зэрэг ажил хийгдсэн бөгөөд уурхайн үндсэн хөрс хуулалтын ажил 3-р сарын 01-ны өдөр эхэлсэн.

Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл оны эцсийн байдлаар нийт 5.5 сая.м3 хөрс хуулалт хийж, 105,500 м3 элс угаан баяжуулж, 5.7 сая.м3 дотоод овоолго хийгдсэн.

Уурхайд нийт 650 орчим ажилчид байрлан ажилласан. Уурхайн нийт ажилчид 3 ээлжинд хуваагддаг бөгөөд 2 ээлж уурхайд ажиллаж байх хугацаанд 1 ээлж ростерийн амралтаар амарч байна. Ээлжийн ажиллах хугацаа уурхайд 20 хоног ажиллаж 10 хоног амарна. Ажиллаж байх хугацаанд 12 цагаар ажиллаж 10 хоногт нэг удаа өдөр, шөнийн ээлж солилцох хуваартай ажилласан.

2. ТӨСЛӨӨС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2017 онд ТЭЗҮ-д нэмэлт тодотголыг батлуулсан тул 2018 онд БОННУнэлгээний нэмэлт тодотголыг “Говь-Эко” ХХК-аар хийлгэж БОАЖЯамаар хянуулж батлуулсан болно. Энэхүү БОННУ-ний тодотголд тус төслийг хэрэгжүүлэх явцад дараах сөрөг нөлөөлөл үүснэ гэж тодорхойлсон байдаг.

2.1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- ✓ Хөрс хуулах, хөрс тээвэрлэх, элс олборлох, аж ахуйн ажил гэх мэт үйл ажиллагааны үед машин, техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх.
- ✓ Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж буй хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хий нь агаарт хаягдаж тухайн орчны агаарын чанарт нөлөөлж болзошгүй.
- ✓ Тоосжилт, хорт хийн ялгаралт, дуу шуугиан гэх мэтээс шалтгаалан төсөл хэрэгжих орчны ойр орчмын айл өрхийн амгалан тайван байдал алдагдах, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй.

2.2. Газрын гадарга, хэвлий, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- ✓ Хөрс хуулалтаас газрын гадаргын унаган төрх өөрчлөгдөх.

- ✓ Тээвэрлэлтийн үед үүсэх тоос, шорооны улмаас газрын гадарга тоосонд дарагдах, бохирдох.
- ✓ Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадарга элэгдэлд орох, хэв шинж өөрчлөгдөх.
- ✓ Газрын гадаргад хоосон (ухсан) орон зай үүсэх.

2.3. Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- ✓ Алт агуулсан элс угаах тоног төхөөрөмжийг байрлуулах үйл ажиллагааны үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар нь алдагдах.
- ✓ Хүн, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрсний шороо суларч, элэгдэл эвдрэлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй.
- ✓ Бензин, тос, дизель (шатах тослох материал) зэргийн асгаралт, ахуйн хэрэглээний хог хаягдлаас хөрсний бохирдол үүсэх.

2.4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- ✓ Шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн зэрэг бодис алдагдах, хур тунадас болон үерийн усаар угаагдан усан орчинг бохирдуулах.
- ✓ Уурхайн ухаш үүсгэх, далан байгуулах, суваг шуудуу татах, хөрс эвдрэлд оруулах зэргээр газрын гадаргын хэлбэр дүрсийг өөрчилснөөр гадаргын урсацын байгалийн унаган тогтоц өөрчлөгдөх.
- ✓ Хур борооны гаралтай эсвэл бусад эх үүсвэр буюу бохирдсон усны шүүрэлт, чөлөөт нэвчилтээр шилжиж ирэх ус тэжээгдэлийн мужаар дамжин газар доорх усыг бохирдуулах.

2.5. Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- ✓ Олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх ухаш, гадаад овоолго болон бусад объектын нөлөөгөөр ургамлан нөмрөг доройтох, устах зэрэг болно.
- ✓ Хүн, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, ургамалан нөмрөг сүйдэх, нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй.

3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Бүрдэл Майнинг” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаварыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, дэмжих зарчмыг баримтлан ажиллаж байна.

Жил бүр нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, шинэчлэн сайжруулж хэрэгжүүлэн ажиллаа.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд удирдлага зохион байгуулалт, нөхөн сэргээлт, агаар, хөрс, усан орчин, ургамал, амьтанд учирж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг менежмент зэрэг хэсгүүдэд хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөж сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээг авч ажиллаа.

Орд ашиглах ТЭЗҮ, Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан нөхөн сэргээлтийн талбай, хэмжээг төлөвлөсөн бөгөөд 2022 онд олборлолтын үйл ажиллагаа явуулахдаа гадаад овоолго үүсгэхгүй, 100 хувь дотоод овоолгоор нөхөн сэргээлийн ажил явуулсан.

Төлөвлөгөөт онд нийт **50** га техникийн, **40.7** га талбайд биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж, **69.8** га талбайд техникийн, **65.3** га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэлийг давуулан биелүүлж ажиллаа. Өнгөрсөн 2021 онд техник нөхөн сэргээлт хийж дууссан талбайд олон наст буурцагт болон үет ургамал тариалан ургуулж биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн.

Сөрөг нөлөөллийг бууруулах, биологийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, хог хаягдлын менежмент, удирдлага зохион байгуулалтын зардал, орчны хяналт шинжилгээ хийхэд шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тооцож хэрэгжүүлэн ажилласан болно. Мөн техникийн нөхөн сэргээлт, байгаль хамгаалах урьдчилан тооцоолох боломжгүй зардлыг үйл ажиллагааны болон үйлдвэрлэлийн зардалд тухай бүр нь тусгаж ажилласан.

Хүснэгт 3. 2022 оны БОМТ-нд тусгагдсан нийт зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8,125,000
2	Биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	15,000,000
	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	3,750,000
3	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох ажлын зардал	500,000
4	Түүх археологийн дурсгал хамгаалах	250,000

5		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,750,000
6		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1,000,000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,500,000
Нийт зардал			35,375,000

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх ажлын зардал болох 35.4 сая төгрөгийг БОАЖЯ-ны тусгай дансанд төвлөрүүлэн ажилласан. /Баримт хавсаргав./

3.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт:

Хөрс хуулалт, тээвэрлэлт, элс олборлох, овоолго үүсгэх, барилга байгууламж барих, зэрэг үйл ажиллагааны үед тоосжилт үүсч төсөл хэрэгжих орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөх, хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хий нь агаарт хаягдаж тухайн орчны агаарын чанарт нөлөөлж болзошгүй зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх 5 ажил арга хэмжээ төлөвлөж ажилласан бөгөөд хэрэгжилтийг доор тайлагнав. Үүнд:

1. Төлөвлөгөөний заалт: Уурхайн технологийн болон дотоод тээвэрлэлтийн зам, зогсоол, талбайд усалгаа хийж чийгшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

- **Биелэлт:** Уурхайн тээвэрлэлтээс үүсч буй тоосжилтыг бууруулах зорилгоор эргэлтийн усан сан дахь усыг ашиглан, зам талбайн чийгшүүлэлт, усалгааг хуурайшилттай үед тогтмол хийж тоосжилтийг бууруулан ажилласан. Зам талбайн усалгааны зориулалтаар FAW маркын тусгай зориулалтын автомашин, CAT 772 автосамосвал 2 ширхэгийг зам усалгааны чиглэлээр тоноглон ашиглаж байна.



Зураг 15, 16. Тусгай зориулалтын машинаар зам услаж тоос дарж байгаа нь.

2. Төлөвлөгөөний заалт: Шинээр гаргах дотоод тээвэрлэлтийн замын шимт хөрсийг авах, хайргаар хучилт хийх, засвар арчилгааг байнга хийж байх.

- **Биелэлт:** Уурхайн хүнд даацын машин техникийн технологийн зам, дотоод тээвэрлэлтийн зам шинээр үүсгэх тохиолдолд зам маршрутыг нарийвчилан төлөвлөж зурагт тусгадаг бөгөөд зам тавихдаа шимт хөрсийг хуулан авч хэлбэржүүлэн, үйлдвэрлэлийн хаягдал болох эфель, галь зэргээр хучиж, сайжруулалт, арчилгааг тогтмол хийснээр бүх машин техникүүд тогтсон зассан замаар явж хөрс эвдэх, тоос үүсэхээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн.



Зураг 17, 18. Автогрейдрээр зам засч арчилгаа хийж зассан зам.

3. Төлөвлөгөөний заалт: Хүнд болон бүх төрлийн машин механизмын хурдыг хязгаарлах, дотоод замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулж тоосжилт бууруулна.

- **Биелэлт:** Уурхайн бүсэд замын аюулгүй байдлыг хангах, машин механизмын хурдыг хязгаарлах, хурд, чиг заасан анхааруулах, мэдээлэх, хориглох тэмдэг бүхий 120 ш замын тэмдэг, тэмдэглэгээг худалдан авч уурхайн бүс, бүх замуудад байрлуулж, хэрэгжилтэд харуул хамгаалалт, ХАБ-ын ажилтнууд байнгын хяналт тавин ажилласан.



Зураг 19, 20. Хурд, чиг заасан, анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ

4. Төлөвлөгөөний заалт: Хүнд машин, механизм, тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд техник үйлчилгээг графикт хугацаанд хийж, тос маслыг тогтсон хугацаанд нь сольж байна.

- **Биелэлт:** Уурхайн ашиглагдаж байгаа хүнд машин, техник, механизм болон үйлчилгээний бусад тээврийн хэрэгсэлд техник, мото цагийн үзлэгийг тогтмол

графикт хугацаанд хийж, тухай бүрт нь буюу дунджаар 20 хоног тутам 1 удаа завсар үйлчилгээг хийж ажиллаа. Үүнд: агаар шүүгч, тосны шүүлтүүр, тос масло зэргийг сольдог. Ингэснээр техникээс ялгарах хорт хийн хэмжээг бууруулан ажилласан бөгөөд агаар дахь нүүрсхүчлийн хэмжээ, тоосжилтыг орчны хяналт шинжилгээгээр тогтоон хяналт тавьж байна. Тухайлбал 2022 онд давхардсан тоогоор 350 техник үйлчилгээний ажил хийсэн нь хүнд машин техникээс ялгарах хорт хийн хэмжээг тодорхой хэмжээгээр бууруулсан.

5. Төлөвлөгөөний заалт: Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих.

- **Биелэлт:** Уурхайн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж буй нөлөөллийн хэмжээг тодорхойлох зорилгоор 6, 9 дугаар сард агаар дахь тоосны агууламж, дуу чимээ, SO₂ болон NO₂ гэсэн үзүүлэлтүүдэд хяналт шинжилгээг Булган, Төв аймгуудийн УЦУОШТөвийн лабораториор хийлгэсэн. Агаарын дээжийг карьер, технологийн зам, кемп орчмын газруудаас авсан болно. Лабораторийн шинжилгээний дүнг хавсралтад оруулав.



Зураг 21, 22. Агаарын шинжилгээний дээж авч байгаа нь.

3.1.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Усны сан бүхий газар, түүний онцгой хамгаалалтын бүс, унд ахуйн худгийн эрүүл ахуйн бүс хог хаягдлаар бохирдох, уурхайн үйл ажиллагаанд өртөх, шатах, тослох материал хөрсөнд алдагдаж хур тунадас, үерийн усаар угаагдан усан орчинг бохирдуулах, ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг зүй зохистой зайлуулаагүйн улмаас гадаргын усыг бохирдуулж болзошгүй, угаан баяжуулах үйлдвэрлэлийн хяналтгүй, тооцоогүй усны нөөц ашиглалт зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах 11 ажил арга хэмжээг авч ажиллаа. Үүнд:

1. Төлөвлөгөөний заалт: Голын онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөх талаар онцгой анхаарч уурхайн ахилтын хэсгүүдэд маркшейдрийн хэмжилтийг өдөр бүр хийж тэмдэг, контур тавьж, Байгаль орчны ажилтан өдөр бүр хяналт тавих, хамгаалалтын бүсэд нүх ухах, зам гаргах зэрэг аливаа үйл ажиллагаа явагдахаас урьдчилан сэргийлж байнгын хяналт тавьж, анхааруулга санамж, сурталчилгаа хийж ажиллана.

- **Биелэлт:** Онцгой хамгаалалтын бүсэд нүх ухах, зам гаргах зэрэг болзошгүй аливаа үйл ажиллагаа явагдахаас урьдчилан сэргийлж бүх хэлтэс, нэгжийн ажилтан

бүрт зориулсан зөвлөмж гарган танилцуулж байнгын хяналт тавьж, газар хөндөх зөвшөөрлийг байгаль орчны ажилтан хянаж олгодог болсон. Мөн шинэ ажилтны сургалт, давтан зааварчилгаагаар давхардсан тоогоор 580 ажилтанд анхааруулга санамж өгсөн байна.

2. Төлөвлөгөөний заалт: Голын эрэг дагуу хог хаягдлыг цэвэрлэх ажлыг сар тутам хийж байх.

- **Биелэлт:** Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг сахих, бохирдохоос сэргийлэн байнгын хяналт тавин ажиллаж байна. Уурхайн инженер техникийн ажилтнууд болон кемп аж ахуйн ажилчид голын эрэг дагуу хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 3-10 сард нийт 8 удаа зохион байгуулж ажиллаа.



Зураг 23, 24. Туул голын эрэг, уурхайн орчмын газарт цэвэрлэгээ хийж байгаа нь.

3. Төлөвлөгөөний заалт: Унд ахуйн усыг хангаж буй гүний худагт эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж, хог хаягдлаар бохирдохоос урьдчилан сэргийлж ажиллах.

- **Биелэлт:** Уурхайн хотхоны унд ахуйн усны хэрэгцээг хангаж буй гүний худагт эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоож, гадны нөлөөллөөс хамгаалж хашаа барьсан нь ундны эх үүсвэр бохирдохоос сэргийлсэн ажил болсон. Худгийн хамгаалалтын бүсэд бохир ус асгах, хог хаягдлыг цэг байгуулах, машин техник явах зэргийг хориглож хог хаягдлыг байнга цэвэрлэж байна.



Зураг 25, 26. Худгийг хашаалсан байдал

4. Төлөвлөгөөний заалт: ШТМ-ын хадгалалт, түгээлтийн технологийн горимыг чанд даган мөрдөх, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах.

- **Биелэлт:** Шатах тослох материал түгээх станц, цэг, агуулах юмкость сав, түгээлтийн машины бүрэн бүтэн байдал, технилогийн горим, нефть бүтээгдэхүүн хөрсөнд алдах, гоожилт асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлэх, үзлэг шалгалтыг уурхайн байгаль орчны ажилтан, галын ажилтан, дотоод хяналтын ажилтан, ХАБЭА-н ажилтнууд өдөр тутам хийж, шалгаж, зөрчил гарсан тохиолдолд цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээг байнга авч ажилладаг. Байнгийн хяналт, үзлэг шалгалтын үр дүнд асгаралт, гоожилт үүсэх нөхцлийг бууруулан ажилласан. Мөн ШТСтанцийн байрлах газрын шимт хөрсийг авч эфелээр 30-50 см зузаантай хучилт хийж өгсөн нь нефть бүтээгдэхүүн хөрсөнд нэвчих, улмаар гүний болон гадаргын усыг бохирдуулах нөхцлийг хязгаарласан болно. Бохирдсон газруудад байгалийн хужиараар саармагжуулалт хийдэг.



Зураг 27, 28. ШТС болон хужир шүү.

5. Төлөвлөгөөний заалт: Хог хаягдлын түр цэгийг гадаргын уснаас хол зайд байгуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлэх, ахуйн бохир усыг цэвэршүүлж, ариутгах, саармагжуулах арга хэмжээ авна.

- **Биелэлт:** Хог хаягдлын цэг нь гадаргын уснаас 600 м хол зайтай байрладаг ба бороо, үерийн усаар дамжин ус бохирдуулах нөхцлийг хязгаарлан хөмсөг, далан хийж хамгаалсан байдаг. Кемпийн бүсэд 20 байршилд нийт 40 ангилан ялгах хогийн сав байрлуулсан. Мөн ариутгал халдваргүйжилтийг байнга хийж ажилладаг.



Зураг 29, 30. Хогийн цэгт шороон далан, хашаа хийсэн байдал

Хогийн цэг, ахуйн шингэн бохирийн цэг, бие засах газрын ариутгал халдваргүйжүүлэлтэд зориулан 2022 онд био ариутгагч Тамир бэлдмэл 200 литр, Жавельон 280 хайрцаг, хлорамин 1200 кг-г авч ашигласан байна.



Зураг 31, 32, 33. Ариутгал хийгдэж байгаа нь.

Хувцас угаалга, усанд орох газар, гал тогооны шингэн бохир усыг цэвэршүүлэх тус бүр 15 м³-н багтаамжтай 3 тунаах сан, шүүрүүлэх септик бүхий бага оврын цэвэрлэх байгууламжийг байгуулснаар бохир ус хөрс орчныг бохирдуулах, хур бороо, үерийн усаар дамжин гадаргын усыг бохирдуулах нөлөөллийг арилгасан.

6. Төлөвлөгөөний заалт: Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу тодорхой цэгүүдээс усны дээж авч шинжилгээ хийлгэнэ.

- **Биелэлт:** Уурхайн үйл ажиллагааны улмаас усны чанарт үзүүлж буй нөлөөллийн хэмжээг тогтоох зорилгоор 6, 9 дүгээр саруудад Булган, Төв аймгийн УЦУОШТөвийн БОШЛаборатораар баяжуулах үйлдвэрийн эргэлтийн усан сан, шүүрлийн усны тунаах нуур, унд ахуйн худгаас усны дээж авч усны химийн ерөнхий шинжилгээг хийлгэж гадаргын усны стандартад нийцэж байгаа эсэхийг тодорхойлсон. Хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй болно. Мөн Туул голын сав газрын захиргаа, Төв аймгийн МХГ-н хяналт шалгалтын явцад шүүрлийн усыг байгаль орчинд нийлүүлж буй хэсгээс дээж авч шинжилгээ хамруулсан. /Шинжилгээний дүнгүүдийг хавсаргав./



Зураг 34, 35. Усны шинжилгээний дээж авч байгаа нь.

7. Төлөвлөгөөний заалт: Үйлдвэрлэлийн хэрэгцээт усыг эргэлтийн усан сангаас хангаж, дахин ашиглах усны хэмжээг 80 хувь болгоно. “Усны тухай” хуулийн дагуу ус ашиглах дүгнэлт гаргуулан, ус ашиглах гэрээг байгуулан, төлбөрөө төлж ажиллана.

- **Биелэлт:** Элс угаан баяжуулах үйлдвэрүүдийн дэргэд эргэлтийн усан байгуулж карьераас гарсан шүүрлийн усыг хийж байна. Эргэлтийн нуураас үйлдвэрлэлийн хэрэгцээт усыг ханган байгаа бөгөөд элс угаасан бохир ус гадагш орчинд гарахгүй нуурт тунаж эргэлтээр ашиглагдаж байна. Ингэснээр усыг 80-90 хувь хүртэл эргэлтээр ашиглаж усны нөөцийг хэмнэж байна.

Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу “Усны газар”-аар 2022.04.12-ны өдрийн №50 тоот ус ашиглах дүгнэлт гаргуулан, Туул голын сав газрын захиргааны даргын 2022.05.23-ны өдрийн А/29 дугаар тушаалаар УНТ 128/22 дугаар бүхий ус ашиглах гэрээг байгуулан ажиллаа. Усны төлбөр төлөх график гарган хуваарийн дагуу төлбөрийг төлж байна.

Мөн “Хаягдал ус”-ны дүгнэлт гаргуулан, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл авч төлбөрийг бүрэн төлж ажиллаа. /Дүгнэлт, зөвшөөрөл, төлбөрийн баримтыг хавсаргав/

3.1.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хөрс хуулалт хийх, зам талбай гаргах, баяжуулах үйлдвэр байгуулах үйл ажиллагааны үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар нь алдагдах, хүн, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрсний шороо суларч, элэгдэл эвдрэлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй, бензин, тос, дизель (шатах тослох материал) зэргийн асгаралт, ахуйн хэрэглээний хог хаягдлаас хөрсний бохирдол үүсэх зэрэг сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах талаар доорх 4 ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаа.

1. Төлөвлөгөөний заалт: Уулын ажлын төлөвлөгөөгөөр карьерын тэлэлт хийгдэж буй талбай, зам, зогсоолын талбайн шимт хөрсийг тухайн газрын гадаргын хэв шинжийн онцлогоос хамааран 30-50 см орчим зузаан хуулж, овоолго үүсгэн хэлбэржүүлж хадгална.

- **Биелэлт:** Уулын ажлын 2022 оны төлөвлөгөөгөөр карьерын тэлэлт хийгдэж буй талбай, шинээр гаргах зам, талбайн шимт хөрсийг тухайн газрын гадаргын хэв шинжийн онцлогоос хамааран 30-80 см орчим зузаан хуулж, 165.0 мян.м3 овоолго үүсгэн хэлбэржүүлснээс гадна техникийн нөхөн сэргээлт хийгдсэн газарт буулган тараасан. Шимт хөрс хуулалтын байдалд байгаль орчны ажилтан тухай бүр хяналт тавьж хэмжилт хийж, уулын мастер, экскаваторын операторт зааварчилгаа өгч ажилладаг.



Зураг 36, 37. Уурхайн ахилтын шимт хөрсийг авч байгаа нь.

2. Төлөвлөгөөний заалт: Шаардлагагүй зам, талбайг үүсгэхгүй байх, маршрутыг оновчтой төлөвлөж, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах. Төлөвлөлтөөс гадуурх талбайд нүх ухах, зам талбай үүсгэх зэргээр хөрсний элэгдэл эвдрэлд орохоос сэргийлж, инженер техникийн ажилчдад анхааруулж байх

- **Биелэлт:** Уурхайн 2022 оны Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөлтийн зураг, сар бүрийн дотоод төлөвлөлтөд уурхайн технологийн зам, паркийн талбай, дотоод тээвэрлэлтийн замын маршрутыг тодорхой тусгадаг. Тухайн зам талбайд байрлуулах тэмдэг тэмдэглэгээг ХАБ-ын ажилтан тодорхойлж байршуулдаг. Мөн зам, талбай байгуулах газрын шимт хөрсийг хуулж аван эфелээр дэвсэлт хийж байнгын засвар арчилгааг хийж байв. Олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж хяналт хийх, зөвлөмж зааварчилгаа өгөх, зөрчилд хариуцлага тооцож ажилласан.

Байгаль орчны ажилтны зөвшөөрөлгүйгээр, төлөвлөлтөөс бусад газарт, шаардлагагүй нүх ухах, зам гаргах зэрэг болзошгүй аливаа үйл ажиллагаа явагдахаас урьдчилан сэргийлж бүх хэлтэс, нэгжийн ажилтан бүрт зориулсан зөвлөмжийг шинэ ажилтны сургалт, давтан зааварчилгаагаар давхардсан тоогоор 580 ажилтанд өгсөн.




Зураг 38, 39. Ажилчдад анхааруулга санамж өгч байна.

3. Төлөвлөгөөний заалт: Засварын газар, ШТС зэрэгт тос, масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс, хужир асгаж саармагжуулна, хог хаягдлыг зориулалтын дагуу устгах

- **Биелэлт:** Нефть бүтээгдэхүүн гоожих, алдагдах, асгарах зэргээр хөрсөн бүрхэвчийг бохирдуулахаас сэргийлж бүрэн бус техник, хэрэгсэл, ШТС-ын агуулах, савын бүрэн бүтэн байдалд байгаль орчны ажилтан өдөр тутам хяналт тавьж, ажлын байрны үзлэг хийж, зөрчлийг арилгуулах, анхааруулах арга хэмжээ авч ажиллаж байна. Тосолгоо үйлчилгээ хийх, шатахуун түгээх ажил гүйцэтгэдэг нэгж хэсгүүдэд өдөр бүрийн ажлын нарыдаар анхааруулга, санамж өгч ажилчдын хайхрамгүй ажиллагаанаас орчны бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Хог хаягдлын цэгийн эргэн тойронд шороон далан, хөмсөг, хашаа хийж хог орчинд тархаж хөрс бохирдуулах эрсдлийг бууруулсан.

Хүнд машин, механизм, техникийн засвар, үйлчилгээг зориулалтын битүү засварын газар, 800 м2 цементэн хучилттай талбайд хийснээр засвар үйлчилгээний явцад нефть бүтээгдэхүүнээр хөрс, орчныг бохирдуулах эрсдлийг бууруулж байна.



Зураг 40, 41. Засвар хийх цементэн талбай.

3.1.4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хөрс хуулалт, уурхайн үйл ажиллагаанаас хоосон орон зай, гадаад овоолго үүсч, газрын гадаргын унаган төрх, хөрсний хэвшинж, давхарга өөрчлөгдөх, шатах, тослох материал (ШТМ) асгарч хөрсөнд нэвчих, ахуйн хог хаягдлаар хөрс бохирдох зэрэг сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах талаар 3 ажил төлөвлөсөн бөгөөд гол хийгдэх ажил нь нөхөн сэргээлтийн ажил юм.

1. Төлөвлөгөөний заалт: Өмнөх жилүүдэд болон төлөвлөгөөт онд уурхайн олборлолтод өртсөн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх.

- **Биелэлт:** Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хоосон орон зайг дүүргэх, гадаад овоолгыг зөөж тэгшлэх техникийн нөхөн сэргээлтийн ажлыг нийт **69.8** га талбайд, **65.3** га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн./Нөхөн сэргээлтийн хэсгээс дэлгэрэнгүй үзэх/

2. Төлөвлөгөөний заалт: Сольсон, хуучин тослох материалыг хадгалах сав зэргийг байршуулж, тодорхой хэмжээнд хүрмэгц тос боловсруулах аж ахуйн нэгжид хүргүүлж байх.

- **Биелэлт:** Машин механизмын засвар үйлчилгээний явцад гарсан хуучин тос маслыг хоосон пошигонд хуримтлуулан тусгай талбайд хадгалж байгаа ба 143.8 тонныг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн.



Зураг 42, 43. Засвар үйлчилгээний явцад гарсан хуучин тос ачиж байна.

3.1.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх ухаш, гадаад овоолго болон бусад объектын нөлөөнөөс ургамалан нөмрөг доройтох, устгах, хүн, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, ургамалан нөмрөг сүйдэх, нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй нөлөөллийг арилгах бууруулах талаар дараах ажил, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээ.

1. Төлөвлөгөөний заалт: Уурхайн нөлөөллийн талбайг нэмэгдүүлэхгүй байх, замын далан, кемп зэрэг боломжтой газруудад ногоон байгууламж байгуулах, үйл ажиллагааны туршид арчилж тордох

- **Биелэлт:** Кемп, уурхайн захиргаа, засварын газрын бүсэд 2.5 га талбайг зүлэгжүүлж олон наст ургамал, цэцгийн мандал, 200 ш хайлаас тарьж ургууллаа. Мөн зүлэг, ургамлыг хамгаалах зорилгоор кемп доторх явган хүний замыг зассан. Шинээр гаргаж байгаа замын шимт хөрсийг авч замын хөвөө далан хийж хэлбэржүүлдэг ба энэ нь байгалийн аясаар ургамал ургаж хөрс салхи, борооны хүчин зүйлийн улмаас элэгдэлд орох нөхцлийг хязгаарлаж өгдөг.





Зураг 44, 45, 46, 47. Кэмпийн бүс дэх зүлэгжүүлэлт, ногоон байгууламж

2. Төлөвлөгөөний заалт: Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад машин механизмуудын хөдөлгөөнийг хориглох, анхааруулсан тэмдэг байршуулж, хяналт тавих, ашиглалтгүй болсон хуучин замуудыг хаах.

- **Биелэлт:** Ургамлан нөмрөг талхлагдахаас сэргийлж тусгай зөвшөөрлийн талбай дахь дотоод тээвэрлэлтийн зам, технологийн замын маршрут гарган замыг хусч янзлан, хөвөө хөмсөг тавьж олон салаа зам үүсэх нөхцлийг хязгаарладаг. Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу сар бүрийн нарийвчилсан төлөвлөгөө гарган ажилладаг ба уг төлөвлөгөөнд технологийн болон суудлын машин зорчих, орон нутгийн машин техник зорчих замыг тусган, тэмдэг тэмдэглэгээг байршуулж ажиллаж байна.



Зураг 48, 49. Зам хаах, хөмсөг далангаар хязгаарлах зэргээр олон салаа зам гарахаа урьдчилан сэргийлж ажиллаж байна.

3.1.6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Уурхайн ойр орчимд тохиолдох зэрлэг амьтад үргэн дайжих, амьдрах орчин хуваагдах, нүүдлийн зам хязгаарлагдах зэрэг нөлөөллүүд үүсч болзошгүй гэж БОННУ-ний тайланд тусгасан байдаг. Урьдчилан сэргийлэх, анхааруулга, санамж өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

1. Төлөвлөгөөний заалт: Зэрлэг амьтдыг үргээх, агнах, ургамал түүх зэрэг хууль бус үйлдэл гаргахгүй байх талаар нийт ажилчдад анхааруулж байх.

- **Биелэлт:** Уурхайн бүсэд тааралдаж болзошгүй ан амьтдыг машинаар хөөх, шувуу, загас барих зэргээр хууль бус үйлдэл гаргахгүй байх талаар шинэ ажилтны сургалт болон ажлын наряд дээр анхааруулга өгдөг.



Зураг 50, 51. Ажилтнуудад сургалтаар Зэрлэг амьтан, шувуу үргээх, хөөх, агнах, ургамал түүх, загас барих зэрэг хууль бус үйлдэл гаргахгүй байх талаар анхааруулдаг

4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.

“Бүрдэл майнинг” ХХК олборлолт явуулж дууссан талбайдаа нөхөн сэргээлтийг үе шаттайгаар хийж дуусгах, нөхөн сэргээлтийг ажлыг гүйцэтгэхдээ “Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх аргачлал”-ын дагуу холбогдох стандартуудад нийцүүлэхийг зорьж ажиллаж байна.

2022 оны нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд шинээр олборлолтод өртөх болон уурхайн өмнөх жилүүдэд олборлолтын үйл ажиллагаа явагдсан хэсгүүдэд нийт 50 га техникийн, үүнээс Булган аймгийн нутагт хамаарах MV-021704 талбайд 12 га, Төв аймгийн нутагт хамаарах талбайд 38 га техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. Биологийн нөхөн сэргээлтийг нийт 40.7 га /Төв аймагт 20.7 га, Булган аймагт 20 га / талбайд хийхээр тусгасан.

Оны эцсийн байдлаар нийт **69.8 га** талбайд техникийн, **65.3 га** талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдсэнийг аймгуудын нөхөн сэргээлтийн комисст газар дээр нь шалгуулан хүлээлгэн өгсөн. Нөхөн сэргээсэн талбай тус бүрээр доор үзүүлэв.

Нөхөн сэргээлтийг цаг хугацаанд нь үр дүнтэй явуулахын тулд бэлтгэл хангах ажлыг оны эхнээс хэрэгжүүлсэн. Тухайлбал:

- Техникийн нөхөн сэргээлт хийх техник хангамж, хүн хүчний нөөцийг бүрдүүлэх.
- Биологийн нөхөн сэргээлт хийх талбайг тэгшилэх, шимт хөрс талбайд буулгаж тараах ажлыг гүйцэтгэх техник, ажиллах хүн хүчний бэлэн байдлыг хангах.
- Нөхөн сэргээлт хийх хэсэг тус бүр дээр нарийвчилсан төлөвлөгөө гаргах, маркшейдрийн хэмжилт хийж ажлын хэмжээг тогтоох, ажлын зураг бэлтгэх.
- Олон наст ургамлын үр худалдан авах компанийг судлаж гэрээ байгуулах

- Тариалалт хийх трактор, үрлэгч техникийн засвар, үйлчилгээг хийж, ажиллах хүнийг орон нутгаас авч гэрээ байгуулах гэх мэт.

4.1. Биологийн нөхөн сэргээлт.

2022 онд “Их тохойрол” ордын хэмжээнд 3 хэсэг газарт нийт **65.3 га** талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн.

- Биологийн нөхөн сэргээлт хийх талбайд 2021 онд техникийн нөхөн сэргээлтийг хийж дуусгасан ба энэ оны 3-5 дүгээр сард шимт хөрсөөр хучих ажил хийгдэж, нийт 195.0 мян.м3 шимт хөрсийг 65 га талбайд 30-50 см зузаантай хучиж олон наст ургамлын үр тариалах бэлтгэл хийгдсэн.

Энэхүү ажлыг CAT 854, CAT D10 маркын 2 ш бульдозер, CAT 390 маркын экскаватор, автогрейдр, МТ-86 маркын автосамосвал 6 ш техникээр 2 сар орчмын хугацаанд хийж гүйцэтгэсэн ба инженер техникийн ажилтан, хүнд машин механизмын оператор зэрэг 20 гаруй хүн ажиллаа.



Зураг 52, 53, 54, 55. Шимт хөрсөөр хучих ажлын явц байдал.

- MV-007712 тусгай зөвшөөрлийн талбай буюу Төв аймгийн Заамар сумын нутагт хамаарах Уул-3 хэсэгт **38.3 га** талбайг тэгшилж янзлах ажлыг хийж, шимт хөрсөөр хучиж, олон наст ургамал тариалсан. Шимт хөрс дэвсэх, тэгшилж засах, хөрс боловсруулах ажлыг ургамлын үрийг тариалалт хийж эхлэх хугацаанаас өмнө дуусган, 6-р сарын 03-ны өдрөөс 6-р сарын 15-ыг хүртэлх хугацаанд олон наст ургамлын үр суулгах, тариалах ажлыг **38.3 га** талбайд хийж гүйцэтгэсэн. /Газрын зураг хавсаргав./

- Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт хамаарах MV-021708 талбайд 27 га талбайд шимт хөрс дэвсэх, тэгшилж засах, хөрс боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн 6-р сарын 15-ны өдрөөс 6-р сарын 20-ыг хүртэлх хугацаанд олон наст ургамлын үр суулгах, тариалалтын ажлыг хийсэн. /Зураг хавсаргав./



Зураг 56, 57, 58, 59. Олон наст ургамлын үр тариалах бэлтгэсэн MV-007712, MV-021708 тусгай зөвшөөрлийн талбай.



Зураг 60, 61. Олон наст ургамлын үр тариалах ажлын явц. MV-007712, MV-021708 тусгай зөвшөөрлийн талбай.

Нийт биологийн нөхөн сэргээлтийн тариалалтад согоовор, хиаг, царгас, хошоон, өлөнгө, судан өвс зэрэг 5 төрлийн олон наст, нэг төрлийн 1 наст ургамлыг сонгож авсан ба 2 төрөл зүйл нь буурцагт, балт ургамал, 3 зүйл нь үет ургамлууд байв. Үрийг “Эвдэрсэн газрыг ургамалжуулах” техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008 стандартад заасны дагуу 1 га талбайд 55 га кг нормоор тариалсан болно.


Биологийн нөхөн сэргээлтийг чанартай, сайн үрээр хийх зорилгоор бэлчээр, тэжээлийн үр импортлогч, тусгай зөвшөөрөлтэй, туршлагатай байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “EHSM” ХХК-аас 2 тонн үр худалдан авч тариалсан. /Үр худалдан авах гэрээ, баримт хавсаргав./



Зураг 62, 63, 64, 65, 66. Биологийн нөхөн сэргээлтэд тариалсан ургамлын үр.

Биологийн нөхөн сэргээлт хийх зориулалтаар МТЗ-80 трактор, СЗП-3.6 үр тариа үрлэгч, хөрс боловсруулах цант борной зэрэг үр тарианы хөдөө аж ахуйн машин техник хэрэгсэлийг худалдан авч 3 дахь жилдээ ашиглаж байна. Өөрийн ХАА-н техник, хэрэгслээр биологийн нөхөн сэргээлтийн ажлыг явуулж байгаа нь амжилттай ургуулах давуу талыг бүрдүүлж байна.

Нөхөн сэргээлтийн ажилд нутгийн иргэдийг оролцуулах, түр ажлын байраар хангах үүднээс Бүрэгхангай сумын иргэн Д.Батсайхан, Б.Нэргүй нарын туршлагатай хүмүүсийг үр тариалах ажилд гэрээгээр авч ажиллуулсан.



Зураг 67. MV-007712 тусгай зөвшөөрлийн талбай дахь биологийн нөхөн сэргээлтийн талбай.



Зураг 68. MV-021708 тусгай зөвшөөрлийн талбай дахь биологийн нөхөн сэргээлтийн талбай.

Техникийн нөхөн сэргээлт.

2022 онд нийт **50 га** техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн ба уулын ажил явагдах MV-007712 тусгай зөвшөөрлийн талбайд уурхайн ашиглалтын явцад гарсан хөрс хуулалтын шороог дотоод овоолгоор явуулж, гадаад овоолго үүсгэхгүй байхаар төлөвлөж ажилласан. Олборлолтын явцад дотоод овоолго хийж, тэгшилэн техникийн нөхөн сэргээлт хийж явах нь хөрөнгө, зардал бага гаргах, цаг хугацаа хэмнэсэн үр дүнтэй технологи юм.

Техникийн нөхөн сэргээлтийн ажлуудын үр дүнд 2022 онд нийт **69.8 га** талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдэж, төлөвлөгөө давж биелсэн. Үүнээс:

- Булган аймагт хамаарах MV-021704 дугаартай ТЗ-н талбайд 4-р сараас өдрөөс техникийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлж 400 мян.м3 шороо зөөвөрлөж карьерт дүүргэлт хийсэн ба эдгээр ажлын үр дүнд **21 га** талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн. Зураг хавсаргав.

- Төв аймагт хамаарах MV-007712 тусгай зөвшөөрөлтэй УулЗ хэсэгт дотоод овоолгоор нөхөн сэргээсэн талбай **48.8 га** болсон бөгөөд техникийн нөхөн сэргээлтийн шаардлагад нийцүүлэн аймгийн комисст хүлээлгэн өглөө. Зураг хавсаргав.



Зураг 69, 70. Техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэж байгаа нь.




Зураг 71, 72. Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайн зураг. MV-007712



Зураг 73, 74. Техникийн нөхөн сэргээлтийн өмнөх ба дараах зураг. MV-021704

“Их тохойрол” ордод 2016-2022 онуудад үйл ажиллагаа явуулах хугацаанд 450 га талбай уулын малталтад өртөгдсөн ба үүний 396.5 га буюу 88 хувьд техникийн нөхөн сэргээлт хийгдээд байна



Зураг 75. Нөхөн сэргээлтийн зураг

Хүснэгт 4. Аймгийн комисст хүлээлгэн өгсөн нөхөн сэргээлтийн талбайн хэмжээ. /га-р/

№	Төв		Булган		Нийт	
	Техник	Биологи	Техник	Биологи	Техник	Биологи
2017	11.9		1.5		13.4	
2018	54.36	5.85	34.1		88.46	5.85
2019	74.9	25.18	30.1	20.5	105	45.68
2020	5.46	13.68	60.7	22.1	66.16	35.78
2021	59.24	27.63	25.35	27.26	84.59	54.89
2022	48.8	38.3	21	27	57.3	65
Нийт	256.16	110.64	172.75	96.86	426.91	207.5

5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

5.1 Нөхөн сэргээлт: Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, уул уурхайн үйл ажиллагаанаас эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайг үе шаттайгаар нөхөн сэргээх ажил хийгдэж байгаа билээ.

Энэхүү зорилтын хүрээнд “Бүрдэл Майнинг” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн нутагт **10 га** эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийж гүйцэтгэлээ.

БОАЖЯамны үүрэг чиглэлийн дагуу Төв аймгийн БОАЖГазар, Заамар сумын Байгаль орчны хяналтын Улсын Байцаагчаас дүйцүүлэх нөхөн сэргээх эвдэрсэн газрыг мэдээллийг авч, 2022 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-д тусган хэрэгжүүлсэн болно.



Байршил	Уртраг			Өргөрөг			
	град	мин	сек	град	мин	сек	
Их тохойрол дүйцүүлэх	PT1	104	31	31.62	48	23	4.8
	PT2	104	31	24.31	48	23	7.3
	PT3	104	31	31.06	48	23	15.3
	PT4	104	31	38.26	48	23	13.6
Баянгол дүйцүүлэх	BG1	104	31	11.07	48	23	2.92
	BG2	104	31	3.86	48	23	6.48
	BG3	104	31	9.45	48	23	14.94
	BG4	104	31	16.34	48	23	11.41

Зураг 76, 77. Дүйцүүлэх нөхөн сэргээлтийн байршил, солбицол.

Дүйцүүлэх нөхөн сэргээлт хийх талбай нь 2000-аад оны эхэн үед уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд өртөж нөхөн сэргээлт хийгдэлгүй эзэнгүй хаягдсан, 5-10 м гүнтэй нүхнүүд, их бага хэмжээтэй овоолгууд зэрэг эмх замбараагүй эвдэрсэн талбай байсан.



Зураг 78, 79. Нөхөн сэргээлт хийхийн өмнөх байдал.

2. Хийгдсэн ажил

Дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажлыг 8-р сарын 20-ээс 9-р сарын 02-ыг хүртэлх 14 хоногийн хугацаанд доорх хүн хүч, техник хэрэгслээр хийж гүйцэтгэв. Эвдэрсэн газрыг байгалийн рельефийн дагуу уусган налуулж тэгшлэх, овоолгыг экскаватороор

шидэж тараах, нүхийг шороо зөөж булах, бульдозероор түрж тэгшлэх, нийт талбайг автогрейдерээр тэгшилж засах ажлууд хийгдсэн.

Ажилласанбүрэлдэхүүн:

- Уулын инженер,
- Байгаль орчны ажилтан,
- Хүнд машин механизмын өдөр, шөнийн ээлжийн 8 оператор, нийт 10 хүн ажиллав

Техникүүд:

- CAT 390 экскаватор -1 ш
- CAT 854 дугуйт дозер -1 ш
- CAT 14М автогрейдр -1 ш
- МТ-86 өөрөө буулгагч -1 ш



Зураг 80, 81. Нөхөн сэргээлтийн ажлын явц.



Зураг 82, 83. Нөхөн сэргээлт хийсний дараах байдал.



Зураг 84, 85. Нөхөн сэргээсэн талбайн булангийн цэгүүдэд тэмдэг, хаяг байрлуулав

5.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдсэн ажил:

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Бүрдэл майнинг” ХХК-ийн 2.5 сая мод тарих ажлын нээлтэд зориулж 5000 ширхэг мод тарих ажлыг Төв аймгийн Заамар сумын нутаг дахь “Их тохойрол” уурхайд зохион байгууллаа.

Мод суулгах, тарих чиглэлээр хийгдсэн ажил:

Мод тарих ажлыг зохион байгуулах төлөвлөгөө, цаашид усалгаа, арчилгаа хийж байх хуваарийг Уурхайн даргын тушаалаар батлуулан, нийт хэлтэс нэгжид мод хуваарилан 6-р сарын 04-13 –ны өдрүүдэд дэс дараатайгаар мод тарих ажлыг зохион байгууллаа.

Модыг Төв аймгийн Заамар сумын нутаг дахь “Их тохойрол” уурхайн Уул-3 хэсэг дэх биологийн нөхөн сэргээлтийн хойд хэсэг, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт байрлах уурхайн кемп, цахилгаан дамжуулах 35кВ-ын дэд станцын хашаа зэрэг байршлуудад суулгалаа. Тухайлбал, Уул-3 нөхөн сэргээлтийн талбайд 4700 ширхэг, кемпийн хашаанд 200 ширхэг, 35 дэд станцын хашаанд 100 ширхэгийг тарьсан.

Байгаль орчны ажилтан мод тарих аргачлал танилцуулж, тарих явцад газар дээр нь зааварчилгаа өгч ажиллаа. Мөн “Платинум Ланд” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн мод тарьсан туршлага, сургамжаасаа танилцуулсан.

Мод суулгах нүхийг дозероор 50 см гүнтэй шуудуу татах, цахилгааны өрмийн машинаар зарим хэсгийг ухуулах, ажилчид гараар ухах зэрэг байдлаар ухаж бэлтгэсэн.



Зураг 86, 87. Мод суулгах нүх ухаж байгаа байдал

Мод тарих ажилд манай компаний “Их тохойрол”, “Баянголын эх” төслийн нийт 300 гаруй уурхайчид оролцож 3-4 настай Хайлаас модны суулгацыг тарьж суулгалаа.



Зураг 88, 89, 90. Мод тарих ажил хийгдэж байгаа нь

Мөн мод тарих ажлын нээлтийг албан ёсоор зохион байгуулж, “Өгөөмөр төгөл” гэж нэрлэхээр тогтож тэмдэгжүүлсэн самбар байрлуулав.



Зураг 91, 92, 93. Үндэсний мод тарих хөдөлгөөнд 250 ажилчин оролцож мод тарьлаа.

Модыг арчилж ургуулах хүрээнд байнгын усалгаа хийж байх хуваарь гаргаж 7 хоногт бүр тусгай зориулалтын машинаар усалгаа хийж байна.



Зураг 94, 95. Тарьсан модыг услах хуваарийн дагуу усалгаа арчилгаа хийж байна.

Орон нутагтай хамтарч ажиллах чиглэлээр:

“Бүрдэл майнинг” ХХК нь Булган аймаг, Заамар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг тул орон нутгийг дэмжих хүрээнд модны тарьц суулгацыг Төв аймгийн Лүн сумын иргэн, хувиараа мод үржүүлэг эрхэлдэг Д.Гомбосүрэнгээс нийт 5000 ширхэг 3 настай хайлаасны суулгац худалдан авсан.



Зураг 96, 97. Хайлаасны суулгац нь тус бүр 200 ширхэгээр багцалсан 25 багц Мөн мод тарих ажилд дэмжлэг болгон Заамар суманд 400 ширхэг, Бүрэгхангай суманд 200 ширхэгийг тус сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагчдын хүсэлтээр хандивлалаа.

Бүрэгхангай сумын ахмадууд 200 хайлаасны суулгацыг ахмадын байрныхаа ногоон байгууламжийг нэмэгдүүлж тарьсан байна.



Зураг 98, 99. Бүрэгхангай сумын ахмадууд мод тарьж байгаа нь

6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Ашигт малтмалын тухай” хуулийн 41-р зүйлийн 41,1-д "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна" гэж заасан.

Хуулийн дээрх зүйл заалтын дагуу олборлолтын бүсэд давхцалгүй боловч нөлөөллийн бүсэд газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий өвөлжөө, хаваржаатай малчдад жил бүр нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгож ирсэн ба 2022 онд нэр бүхий 17 малчинд 42 сая төгрөгийн нүүлгэн шилжүүлэлтийн зардал болон нөхөн олговор өгсөн.

Нийгмийн хариуцлагын гэрээ, нөхөн олговор олгох арга хэмжээний хүрээнд олон ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал: ойр орчимд нутагладаг малчин өрхүүдэд нөхөн олговор олгох, худаг гаргаж өгөхөөс гадна нутгийн иргэдээс 350 сая төгрөгийн мах, 18 сая төгрөгийн хүнсний ногоо худалдан авсан нь малчид зах зээлийн үнээр, тээврийн зардалгүй мал махаа борлуулж орлого олоход томоохон дэмжлэг болсон гэж үзэж байна.

7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Монгол улсын "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулийн 6 дугаар бүлгийн 17.10 дугаар заалтын дагуу ШУА-ийн Палентеологийн Төв, Түүх, архелогийн хүрээлэнгийн судлаач, эрдэмтэд төсөл хэрэгжиж байгаа нутаг дэвсгэрт хээрийн судалгаа хийсэн ба тус судалгаатай холбоотой дүгнэлт, тайланг 2016 онд гаргасан.

Уг дүгнэлтэд тусгай зөвшөөрлийн талбайд тархсан геологийн чулуулаг хурдаснаас эртний түүхэн амьтдын үлдвэр илрээгүй болохыг тодорхойлсон байдаг. Харин археологийн дурсгал болох булш, хиргэсүүр бүртгэгдсэн байдаг ба тайлан, дүгнэлтэд тусгагдсаны дагуу хяналт тавин ажиллаж байна.

Кемп, зам, талбайн ойролцоо зэрэг нөлөөлөлд өртөж болзошгүй археологийн дурсгал болох хиргэсүүр, дөрвөлжин булшийг хашиж хамгаалж /нийт 6 хашаа/, үйл ажиллагаанд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна.



Зураг 100, 101. Археологийн дурсгалыг хамгаалсан хашаа.

8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагааны явцад учирч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тооцох зорилгоор “Уурхайн гамшигийн эрсдэлийн үнэлгээ” хийлгэсэн бөгөөд хэрэгжүүлэх ажлыг тусгасан “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г жил бүр батлуулан ажиллаа.

Уурхайн “ЭМААБО”-ны хэлтсийн бүрэлдэхүүнд 3 хүнтэй орон тооны Галын аюултай тэмцэх хэсэг ажилладаг бөгөөд галын зориулалтын машин, багаж тоног хэрэгслээр хангагдсан байдаг. Мөн уурхайн даргын тушаалаар Гамшигийн үед ажиллах шуурхай хэсгийг томилон, ажиллах зааврыг батласан байдаг.

Аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх доорх ажлууд хийгдсэн. Үүнд:

- Гэнэтийн аадар бороо, шар усны үерт өртөж болзошгүй хэсгүүдэд далан хаалт тавьсан. Засварын газрын барилга, сэлбэгийн агуулах, гал тогоо зэрэг томоохон барилгыг тойруулан ус зайлуулах суваг хийсэн.
- Шатахуун түгээх станц, үүрэн телефоны антенны ойролцоо аянга зайлуулагч байрлуулсан ба цахилгаан хувиарлах КТП –дэд газардуулга хийж аюулгүй байдлыг хангасан.



Зураг 102, 103. Ус зайлуулах суваг, аянга зайлуулагч

- Байгаль орчны болон ХАБ-ын ажилтнууд цаг агаарын мэдээг байнга сонсож, ажиглаж хүчтэй салхи, онц ноцтой үзэгдэлийг анхааруулан ажилладаг. Сууцны гэрүүдийг даруулж бэхлэх, уурхайн үйл ажиллагааг түр зогсоох зэрэг шаардлагатай арга хэмжээг авч байна. Өндөр хүчдэлийн аюулгүйн бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулахаас цахилгааны инженер, ХАБ-н ажилтан хяналт тавьдаг.
- Үйлдвэрлэлийн болзошгүй осол, гал түймэр, газар хөдлөлт зэрэг аюулын үеийн бэлэн байдлыг шалгах, ажилчдын цуглах цэг, техникийн хөдөлгөөнийг зохицуулах, галын машин зэрэг тусгай зориулалтын техник хэрэгсэл, хүн хүчний бэлэн байдлыг шалгах зорилгоор 2 удаа нийтийг хамарсан дадлага сургуулилт зохион байгууллаа.



Зураг 104, 105. Дадлага сургуулийн үе

- Шинээр ажил орж буй ажилчдыг ЭМШУИСургуулийн харьяа Нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн шинжилгээ, үзлэгт оруулдаг бөгөөд ажилтан бүрт эрүүл мэндийн хяналтын дэвтэр хөтлөдөг.

Уурхайн нийт ажилчдыг хамруулан эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийж исэн ба 2022 онд нийт ажилчдад сүрьеэ өвчний шинжилгээ, рентгенд харах эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн. Ковид өвчинтэй холбоотой тандан шинжилгээ авах, тусгаарлах кемп байгуулах, ариутгал халдавгүйжүүлэлтийг тогтмол хийх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Их тохойрол” алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны явцад гарсан хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан ажиллаж байна.

- ✓ Уурхайн бүсэд хог хаягдлын талаар баримтлах журмыг гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан хогийг ангилан ялгах, дахин ашиглах, түүхий эдэд тушаах, ачуулах, булшлах зэргийг хог хаягдлын төрөл тус бүрээр тодорхойлон тусгаж, мөрдөн ажилласан.
- ✓ Уурхайн тосгон, хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааны хүрээнд хог хаягдлыг төрөлжүүлэн ялган ангилж, цуглуулах хогийн сав 50 ширхэгийг байрлуулсан.



Зураг 106, 107. Хог ангилан хаях сав, цэг.

- ✓ 2022 онд Хог хаягдалын гэрээг Бүрэгхангай, Заамар сумдтай байгуулан, гэрээнд заасны дагуу үйл ажиллагаа явуулж, 7 сая төгрөгийн төлбөрийг төлж ажилласан./гэрээ, төлбөрийн баримт хавсаргав./
- ✓ Хогийн цэг, ахуйн шингэн бохирийн цэг, бие засах газрын ариутгал халдваргүйжүүлэлтэд зориулан 2022 онд био ариутгагч Тамир бэлдмэл 200 литр, Жавельон 280 хайрцаг, хлорамин 1200 кг-г авч ашигласан байна.



Зураг 108, 109. Ариутгалын бодисууд

- ✓ Хоггүй цэвэр орчинд ая тухтай ажиллаж амьдрах үүднээс кемпийн орчмын газар, Засварын газар, баяжуулах үйлдвэр зэрэг газруудад бүх нийтийн цэвэрлэгээг 14 хоног тутамд бямба гараг бүр зохион байгуулж бүх ИТА-д оролцдог. Уг бүх нийтийн цэвэрлэгээнд уурхайн бүх нэгж хэсгүүд, ажилчид оролцож, ажлын байр, кемп, орон нутгийн зам, голын эрэг зэрэг газруудын хог хаягдлыг цэвэрлэдэг.



Зураг 110, 111. Орчны цэвэрлэгээг нийт ИТА-ыг хамруулан хийдэг.

- ✓ Ахуйн шингэн бохирыг цэвэршүүлэх байгууламжаас гарч байгаа саарал усыг Булган, Төв аймгийн УЦУОШТөвийн лабораторид 2 удаа шинжилгээнд хамруулсан ба цэвэршүүлэлтийн зэрэг 75 хувь байна./Шинжилгээний дүнг хавсаргав./

- ✓ Засварын газраас гарах ашигласан тос, нефть бүтээгдэхүүн, шланк, агаар шүүгч, тосны шүүр зэрэг аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид гэрээний дагуу шилжүүлж байна. Энэ онд 143.8 хаягдал тос, тонн аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагуудад шилжүүлсэн болно. Гэрээ, баримтыг хавсаргав.



Зураг 112, 113. Хуучин тосыг эрх бүхий байгууллагад шилжүүлдэг.

- ✓ Авто засварын газраас гардаг хог хаягдлын сөрөг нөлөөллийг багасгах, байгаль хор нөлөөгүй устгах аргыг чухалчилсан ба сольсон агаар шүүгчийг ашиглан тамхины хогийн сав, зогсоолын тэмдэгжүүлэлт, хаягдал пошкаар хатуу хог хаягдлын сав, сандал, сав баглааны хаягдал модоор сүүдрэвч, сандал зэргийг хийж ашиглаж байна.



Зураг 114, 115, 116, 117. Хаягдал материал ашиглаж хийсэн зүйл.

- ✓ Эмнэлгийн хог хаягдлыг Бүрэгхангай сумын эмнэлэгтэй гэрээ байгуулж журмын дагуу устгуулж байна.

Хог хаягдлыг багасгах, дахин ашиглах хоёрдогч түүхий эдэд тушаах үр дүнтэй аргуудыг хэрэгжүүлэхийг зорьж ажилладаг бөгөөд тухайлбал, дахин ашиглагдах, дахин боловсруулагдах хог хаягдлыг зориулалтын сав байрлуулж, цуглуулдаг зэрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээг доор дэлгэрэнгүй оруулав.

Хаягдал дугуй: Одоогоор дахин ашиглах боломжгүй дугуйг хогийн цэгт цуглуулдаг ба баяжуулах үйлдвэрийн суурийн ажилд ашигладаг.

Хаягдал төмөр: Тусгай талбайд цуглуулж байгаа бөгөөд тодорхой хэмжээнд хүрсний дараагаар хоёрдогч түүхий эд авах цэгт тушаана.

Хаягдал поошиг: Хоосон поошгийг тусгай цэгт цуглуулж, тодорхой хэмжээнд хүрсний дараагаар Улаанбаатар хот хүргүүлж цаашид хоёрдогч түүхий эд болгон ашиглах хувь хүн, байгууллагад тушаадаг. Энэ онд нийт 327 хоосон поошиг Улаанбаатар хотруу ачуулсан.



Зураг 118, 119. Хоосон поошиг ачуулсан байдал.

Цаас ба картон: Оффисоос гарч буй цаас болон бусад картон цаасыг хогийн саванд цуглуулж, гэр кемпийн галлагаанд ашигладаг.

Шингэн хог хаягдлын зохицуулалт: Уурхайн халуун ус, хувцас угаалга, гал тогоо шингэн бохир усыг цэвэршүүлэх септик бүхий 3 дамжлагат бага оврын цэвэрлэх байгууламжийг байгуулснаар бохир ус хөрс орчныг бохирдуулах, хур бороо, үерийн усаар дамжин гадаргын усанд нөлөөлөх .

10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Байгаль орчны хууль, тогтоомжийг баримталж, төлөвлөгөө, гэрээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэхэд удирдлага, зохион байгуулалтын ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаа. Орон нутагт мэдээ тайлан хүргүүлэх, байгаль хамгаалал нөхөн сэргээлтийн талаар сурталчлах, байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлууд хийгдсэн. Үүнд:

1. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгоор 2 баримт бичгийг боловсруулан ажиллаж байна. Үүнд:

- Уурхайн олборлолтын үйл ажиллагааны үед компаний бүх ажилчид, хэлтэс нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор мөрдөх зөвлөмж
- Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх журам, төлөвлөгөө

2. 2022 онд ажиллах Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Газрын гэрээ, ус ашиглах дүгнэлт, гэрээ, Нийгмийн хариуцлагын гэрээ, хог хаягдлын гэрээг БОАЖЯам, АМГТГазар, Туул голын сав газрын захиргаа, Булган, Төв аймгийн БОАЖГазар, Бүрэгхангай, Заамар сумын захиргаа зэрэг байгууллагаар хянуулан батлуулж, гэрээ байгуулан ажилласан.

Уурхай дээр байх бичиг баримтыг бүрдүүлэн ажилласан ба УМХЕГ, Төв, Булган аймгуудын МХГ-ын шалгалтаар ил уурхайг шалгах хуудсаар дүгнэхэд эрсдэлгүй гэж дүгнэгдсэн.

3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөт ажлыг цаг хугацаандаа хийж гүйцэтгэх зорилгоор сар бүр нарийвчилсан төлөвлөгөө гарган байв. Төлөвлөгөөг байгаль орчны ажилтан болон төлөвлөлтийн инженер хамтран гаргаж сар бүр гүйцэтгэлийг гаргадаг.

4. Нөхөн сэргээлтийн мэдээ, судалгаа, байгаль орчны төлөвлөгөөний дагуу хийгдэж буй ажлын талаар Булган, Төв аймгийн БОАЖГазар, Экологийн цагдаагийн алба, Заамар, Бүрэгхангай сумдын БОХУБайцаагч нарт давхардсан тоогоор 8 удаа мэдээ, судалгаа явуулсан байна.

5. ОБЕГазрын харьяа Уул уурхайн аврах албаны мэргэжил арга зүйн зөвлөлгөө авч хянуулсны үндсэн дээр Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан ажилласан. Гал түймэр, байгалийн гэнэтийн аюулын үед хэргэжүүлэх бэлэн байдлын дадлага сургуулилтыг 2 удаа зохион байгуулсан.

6. Нөхөн сэргээлтийн туршлага судлах зорилгоор Платинум ланд, Шижир-Алт компаниудын нөхөн сэргээлтийн талбайтай танилцан, байгаль орчны ажилтнууд арга туршлагаа солилцож байна.

7. Хавар намар 6, 10 дугаар сард Заамар сумын Хайлааст багийн ИНХуралд оролцож нөхөн сэргээлтийн ажил, байгаль орчны ажлын талаар танилцуулсан.

Эдгээр арга хэмжээний үеээр иргэдээс байгаль орчныг хамгаалах талаар гарсан санал, шүүмжлэлийг хүлээн авч зарим ажлыг хэрэгжүүлсэн болно.

8. Сөрөг нөлөөллийг багасгах, нөхөн сэргээлтийн ажилд зориулсан техник, тусгай зориулалтын машин худалдан авах асуудлыг удирдлага зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлүүлж биологийн нөхөн сэргээлт хийх газар тариалангийн трактор, үрлэгч, борной зэрэг техник хэрэгсэл, зам талбайн усалгаа хийх тусгай зориулалтын 2 машин тус тус үйл ажиллагаандаа ашиглаж байна.

9. Уурхайд шинээр ирж буй ажилчдыг хүлээн авч Байгаль орчны талаар анхааруулга, санамж өгдөг бөгөөд ажил үүргээ гүйцэтгэх, амрах үедээ хог хаягдлыг зориулалтын бус газар хаях, замгүй газраар техникийн хөдөлгөөн хийхгүй байх, ан амьтан, загас, шувуу агнах, үргээх, хөөхийг хориглох зэрэг анхааруулга санамж өгч,


тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилтуудыг таницуулдаг.

2022 онд нийт 165 шинэ ажилтанд сургалт явуулсан. Мөн сар бүр давтан зааварчилга өгч хэвшсэн. Давхардсан тоогоор 380 ажилтанд давтан зааварчилгаа өгч гарын үсгээр баталгаажуулсан болно.

11. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулиудын дагуу хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлалыг хангасан багаж тоног төхөөрөмж бүхий мэргэжлийн байгууллагаар хяналт шинжилгээг хийлгэлээ.

Энэ онд Төв аймгийн УЦУОШТөвөөр 6 дугаар сард, 9-р сард Булган аймгийн УЦУОШТөвтэй гэрээ байгуулан тус тус хамтран ажиллаж орчны хяналт шинжилгээ, шүүрлийн усны шинжилгээний ажлыг гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Нэг удаад агаарын дээжийг 3 цэгээс 2 элементээр 2 удаа, хөрсний дээжийг 3 цэгээс 1 удаа агрохими, хүнд металлын үзүүлэлтээр, ундны усны дээжийг 2 цэгээс 1 удаа, карьерын усыг 3 цэгээс 1 удаа, цэвэршүүлсэн ахуйн бохир уснаас 1 удаа дээж авч шинжилгээний хариуг ирүүлсэн. /Гэрээг, шинжилгээний дүнг хавсаргав/



Схем зураг 2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлсэн аргачлал

Их тохойрол алтны шороон орд ашиглах төслийн олборлолтын талбайн дахь карьер, технологийн зам, кемп, эргэлтийн усан сан, унд ахуйн худаг, нөхөн сэргээлтийн талбай, шимт хөрс, шатахуун түгээх станц, засварын газар зэрэг бүхий л газрууд хамрагдаж агаар, хөрс, усны дээж авсан болно.

11.1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр – Агаар


Дээрх цэгүүдээс орчны дуу чимээ, тоосны агууламж, хүхэр болон азотын давхар исэл зэрэг элементүүдэд шинжилгээ хийсэн ба MNS4585:2016 Агаарын чанарын стандартын хүлцэх хэмжээнээс “бага” буюу байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөлгүй хэвийн байна. Лабораторийн шинжилгээний дүнг хавсралтад оруулав.

11.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр – Хөрс

Дээрх цэгүүдээс дээж авч, хөрсөнд агуулагдах хүнд металл (Cd, Pb, Hg, Br, Cr, Zn, Cu, Co, Sr, Rb, Zr)-ын шинжилгээг хийсэн ба Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2008, MNS3391:91 стандартын хэмжээнээс “бага” буюу байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөлгүй хэвийн байна. Лабораторийн шинжилгээний дүнг хавсралтад оруулав.

11.3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр – Усан орчин

Гадаргын ус буюу уурхайн шүүрлийн ус, гүний ус буюу хотхоны унд-ахуйн усны шинжилгээний дүнгээс үзэхэд Ундны болон гадаргын усны стандарт MNS4586:1998, MNS900:2005-ын шаардлага хангаж байна. Лабораторийн шинжилгээний дүнг хавсралтад оруулав.



Зураг 120, 121, 122, 123, 124, 125. Шинжилгээний дээж авч байгаа байдал.

12. БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН ХУВААРЬ

Их Тохойрол алтны шороон ордыг ашиглах төслийн үндсэн үйл ажиллагаа буюу ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбай нь Булган аймгийн Бүрэгхангай сумын Дэрст баг, Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн нутагт байрладаг. Тиймээс энэхүү төслийн нөлөөлөлд өртөгчид мөн төсөлд оролцогч талууд нь эдгээр 2 сум болно.

Хүснэгт 5. БОМТ-ний тайлан, нөхөн сэргээлтийн мэдээг тайлагнасан мэдээ.

Д/д	Тайлан, мэдээ	Тайлан мэдээ хүргүүлсэн байгууллага.	Мэдээллийн агуулга	Хугацаа	Тайлан мэдээ явуулсан.
1	2022 оны БОМТөлөвлөгөө хянуулж батлуулан, холбогдох газруудад хүргүүлэв.	-БОАЖЯам, -Төв, Булган аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар, -Заамар, Бүрэгхангай сумдын БОХУБ	Шинээр батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдэх нөхөн сэргээлт, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	3 -р сард	
2	2022 оны БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, мэдээг хүргүүлэв.	-Төв, Булган аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар -Экологийн цагдаагийн алба -Заамар, Бүрэгхангай сумдын БОХУБ	-Нөхөн сэргээлтийн ажлын явцын мэдээ, -Ус, газар ашиглах зөвшөөрөл, гэрээ, төлбөрийн мэдээлэл	Улирал бүр	Байгаль орчны мэргэжилтэн
4	Тайлан танилцуулж хэлэлцүүлэх	- Бүрэгхангай ИТХ, - Заамар сумын ИТХ-н Тэргүүлэгчид	-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын дүн мэдээ	2022 оны 6,9 дүгээр сард	
5	ОУИТБС-ын тайлан оруулав.	ОУИТБС-ын ажлын алба, цахим тайлангийн систем	-Нөхөн сэргээлт -Татвар, төлбөр, хандив	1-р улиралд	Нягтлан бодогч
6	Олон нийтэд нээлттэй байх	Орон нутаг, багийн иргэд	-Бүрэгхангай сумын Дэрст багийн иргэдэд	9-р сард	Байгаль орчны мэргэжилтэн

13. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР:

Уурхайн үйл ажиллагааг шалгах, хяналт тавих, зөвлөн туслах чиглэлээр Төв, Булган аймгийн МХГазар, Туул голын сав газрын захиргаа, Төв, Булган аймгийн БОАЖГазар, Экологийн цагдаагийн алба, Заамар, Бүрэгхангай сумдын ЗДТГазар зэрэг улс, аймаг, сумын төрийн байгууллагаас хяналт шалгалтын ажил явуулсан.

Тухай бүрд жилийн ажлын төлөвлөгөөнүүд, гэрээ, зөвшөөрөл зэрэг уурхай дээр байх ёстой бичиг баримтын бүрдлийг шалгуулан, газар дээр нь танилцуулж ажилласан болно. Албан шаардлага, мэдээ, судалгааны хариуг цаг хугацаанд нь хүргүүлж, тавьсан үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан.

-----oOo-----

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

№	Материал	Хуудас
1	Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ	1
2	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтын хуулбар. /MV-007712, 021704/	6
3	Байгаль орчныг хамгаалах баталгааны мөнгөн хөрөнгө байршуулсан баримт	1
4	БОХШ-ны гэрээ Төв, Булган аймаг шинжилгээний дүнгүүд	20
5	Хог хаягдлын гэрээ, төлбөрийн баримт	3
6	Хуучин тос, тосны шүүр, шланк нийлүүлэх гэрээ, баримт	4
7	Нөхөн сэргээлтийн топо зурагнууд	2
	Нийт:	37

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000197175

2013.06.19

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011419045

/ Хувийн хэргийн дугаар /

5722942

/ Регистрийн дугаар /

Бүрдэл майнинг

Хязгаарлагдмал хариуцлагатай
компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2013.06.18

/ он, сар, өдөр /

4610
0990

/ Код /

Гадаад худалдаа

Ашигт малтмалын ашиглалт / 2015.07.07-2045.07.07/

/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

29,817,947.35

/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал Тауэр 1210-1213 тоот,

Утас1: 88012475, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн
газар

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2020 он 01 сар 30 өдөр

ГСТ6115 1118268501

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Паламсүрэн овогтой Төмөрцэцэг-г Захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2018.08.14	Э.Эрдэнэбилэг
2	Дахин гэрчилгээ олгов.	2020.01.30	М.Монголжин
3	Уртнасан овогтой Угтах-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2020.10.14	Д.Гангамөрөн



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээгэнэ. Улсын бүртгэлийн гэрчийгээ засвартай бол хүчингүй.



* 0 0 0 1 9 7 1 7 5 *



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛААЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 7712А

Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар
зүйлийг үндэслэн

Төв, Булган аймаг /хот/-ийн

Завсар, Бүрээхангай сум /дүүрэг/-ын

Ух тохойрол нэртэй газарт орших

2534 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд

заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн 9019021012 тоот гэрчилгээтэй

„Ух тохойрол, ДТХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 30 жилийн

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.



ДТХК-ЫН НЭРЛÜГЭЭР ОРЛОГЧ

Ц. ГАНХУЯГ

2007 оны 01 сарын 23 өдөр



Улаанбаатар хот



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-007712

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
037-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 18 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.06.11 – 2022.06.11 хүртэл	 <p>2021.06.07</p>
038-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 19 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.06.11 – 2023.06.11 хүртэл	 <p>2022.06.15</p>



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-007712

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

035-SPR	<ul style="list-style-type: none">Тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн буцаан өгөх Шийдвэрийн огноо: 2020.09.28 <p>2020.09.28</p>	512.96 Га	1740.64 Га	<ol style="list-style-type: none">1 104° 27' 33.08" 48° 20' 50.75"2 104° 27' 33.08" 48° 20' 22.84"3 104° 27' 45.28" 48° 20' 22.84"4 104° 27' 45.28" 48° 20' 14.05"5 104° 28' 4.77" 48° 20' 14.05"6 104° 28' 4.77" 48° 20' 1.82"7 104° 26' 50.95" 48° 20' 1.82"8 104° 26' 50.93" 48° 19' 36.81"9 104° 25' 40.94" 48° 19' 36.81"10 104° 25' 40.94" 48° 19' 6.81"11 104° 24' 42.94" 48° 19' 6.81"12 104° 24' 47.17" 48° 19' 19.71"13 104° 24' 47.47" 48° 19' 24.98"14 104° 24' 47.45" 48° 19' 35.77"15 104° 24' 46.92" 48° 19' 43.45"16 104° 24' 44.03" 48° 19' 49.57"17 104° 24' 40.03" 48° 19' 57.83"18 104° 24' 36.04" 48° 20' 2.77"19 104° 24' 30.37" 48° 20' 6.21"20 104° 24' 30.39" 48° 20' 8.46"21 104° 24' 34.65" 48° 20' 9.75"22 104° 24' 45.09" 48° 20' 8.79"23 104° 24' 55.06" 48° 20' 6.09"24 104° 24' 59.99" 48° 20' 0.89"25 104° 25' 11.72" 48° 19' 55.36"26 104° 25' 24.97" 48° 19' 54.05"27 104° 25' 33.11" 48° 19' 58.98"28 104° 25' 33.39" 48° 20' 6.34"29 104° 25' 22.6" 48° 20' 10.61"30 104° 25' 12.84" 48° 20' 13.05"31 104° 25' 21.31" 48° 20' 19.08"32 104° 25' 29.82" 48° 20' 13.63"33 104° 25' 46.41" 48° 20' 16.7"34 104° 26' 0.67" 48° 20' 21.39"35 104° 26' 4.02" 48° 20' 17.16"36 104° 26' 18.04" 48° 20' 15.1"37 104° 26' 25.52" 48° 20' 21.4"38 104° 26' 25.73" 48° 20' 26.95"39 104° 26' 17.13" 48° 20' 34.97"40 104° 26' 23.33" 48° 20' 40.5"41 104° 26' 28.03" 48° 20' 33.75"42 104° 26' 31.12" 48° 20' 25.34"43 104° 26' 39.74" 48° 20' 17.03"44 104° 27' 8.03" 48° 20' 20.78"45 104° 27' 8.68" 48° 20' 29.53"46 104° 27' 20.99" 48° 20' 36.46"47 104° 27' 21.08" 48° 20' 48.28"
---------	---	-----------	------------	---

2020-09-28 Д.Чинзориг





АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар **MV-021704**

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Булган, Төв аймаг /хот/-ийн

Бүрэгхангай, Заамар сум /дүүрэг/-ын

Их Тохойрол нэртэй газарт орших

370.31 гектар талбай бүхий уурхайн талбайд

хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн 9011419045 тоот гэрчилгээтэй


“Бүрдэл хайгууль” ХХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 2034.06.11 дуустал

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТЭСНИЙ
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БАТМАГНАЙ

2020 оны 9 сарын 28 одор

Улаанбаатар хот

0000496



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-021704

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
001-SPD	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Анх 2004.06.11-нд олгосон, 2034.06.11 дуусах тусгай зөвшөөрлийн талбай хуваагдаж шинээр үүссэн тусгай зөвшөөрөл олгохКадастрын хэлтсийн даргын 2020.09.28-ний 364 тоот шийдвэр	<div data-bbox="1150 524 1453 651" style="border: 1px solid red; padding: 5px; display: inline-block;">2 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС 2020.09.28</div>
003-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 18 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.06.11 – 2022.06.11 хүртэл	<div data-bbox="1118 972 1422 1099" style="border: 1px solid red; padding: 5px; display: inline-block;">1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС УХАД595</div>
004-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 19 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.06.11 – 2023.06.11 хүртэл	2021.06.07 <div data-bbox="1142 1196 1445 1323" style="border: 1px solid red; padding: 5px; display: inline-block;">1 АМГТГ ГЕОДЕЗИ, ЗУЛУУРХАЙН КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ07043</div>
		2022.06.15



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-021704

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				#	Уртраг	Өргөрөг
001-SPD	<ul style="list-style-type: none">Анх 2004.06.11-нд олгосон, 2034.06.11 дуусах тусгай зөвшөөрлийн талбайг хувааснаар шинэ тусгай зөвшөөрөл олгох Шийдвэрийн огноо: 2020.09.28 <p>2020.09.28</p>	370.31 Га	0 Га	1	104° 26' 8.85"	48° 20' 32.83"
				2	104° 26' 17.73"	48° 20' 22.5"
				3	104° 26' 12.32"	48° 20' 19.42"
				4	104° 26' 4.63"	48° 20' 25.99"
				5	104° 25' 56.02"	48° 20' 26.66"
				6	104° 25' 44.43"	48° 20' 22.22"
				7	104° 25' 39.69"	48° 20' 24.06"
				8	104° 25' 34.43"	48° 20' 28.22"
				9	104° 25' 15.65"	48° 20' 22.58"
				10	104° 25' 4.56"	48° 20' 13.82"
				11	104° 25' 7.28"	48° 20' 8.41"
				12	104° 25' 24.83"	48° 20' 4.84"
				13	104° 25' 26.08"	48° 20' 1.08"
				14	104° 25' 16.79"	48° 19' 59.18"
				15	104° 25' 9.16"	48° 20' 6.22"
				16	104° 25' 0.53"	48° 20' 9.73"
				17	104° 24' 48.28"	48° 20' 13.38"
				18	104° 24' 33.94"	48° 20' 14.64"
				19	104° 24' 24.02"	48° 20' 10.51"
				20	104° 24' 22.77"	48° 20' 2.55"
				21	104° 24' 30.24"	48° 19' 58.73"
				22	104° 24' 31.22"	48° 19' 48.1"
				23	104° 24' 36.68"	48° 19' 41.81"
				24	104° 24' 11.93"	48° 19' 41.81"
				25	104° 24' 11.93"	48° 19' 6.81"
				26	104° 23' 46.94"	48° 19' 15.81"
				27	104° 23' 37.94"	48° 19' 6.81"
				28	104° 23' 30.94"	48° 19' 6.81"
				29	104° 23' 30.94"	48° 20' 15.17"
				30	104° 24' 8.26"	48° 20' 15.17"
				31	104° 24' 8.26"	48° 20' 21.61"
				32	104° 24' 22.41"	48° 20' 21.61"
				33	104° 24' 22.41"	48° 20' 29.48"
				34	104° 24' 57.18"	48° 20' 29.48"
				35	104° 24' 57.18"	48° 20' 42.41"
				36	104° 25' 26.62"	48° 20' 42.41"
				37	104° 25' 26.62"	48° 20' 49.52"
				38	104° 26' 19.83"	48° 20' 49.79"
				39	104° 26' 19.86"	48° 20' 44.22"
				40	104° 26' 12.66"	48° 20' 43.86"

3
2020-09-28
АМГТ
КАДЕТРИН ХЭЛТЭС
З.А.О. Д. Чинзориг
УХА0595

Он/YY: 2022.05.06
 Сар/ММ: 06
 Өдөр/DD: 06

Хүлээн авагчийн / Beneficiary's:

Банкны нэр / Bank name:	Дансны № / Account №:	Нэр (байгууллага эсвэл иргэн) / Name (organization or individual):
MOF (TREASURY FUND)	100900013406	БО нөхөн сэргээх баталгаа
Мөнгөн дүн тоогоор / Amount:	Мөнгөн дүн үсгээр / Amount in word:	Валют / Currency:
12,970,000.00	Арван хоёр сая есөн зуун далан мянган төгрөг	MNT
Гүйлгээний утга, бусад тэмдэглэл / Details of payment:		Нууц код / Code:
БҮРДЭЛ МАЙНИНГ ХХК -С БАЯНГОЛ ЭХ ОРД 2022ОНЫ БОМТ ЗАРДЛЫН 50%		

Шилжүүлэгчийн / Sender's:

Банкны нэр / Bank name:	Дансны № / Account №:	Нэр (байгууллага эсвэл иргэн) / Name (organization or individual):
TRANS BANK	90200172	АЗЗАЯА 902
Мөнгөн дүн тоогоор / Amount:	Валют / Currency:	Гүйлгээний төрөл / Transaction type:
12,970,000.00	MNT	Банк хооронд бэлэн мөнгө шилжүүлэх
Харилцагчийн тэмдэглэл / Customer note:		
100900013406 (12'970'000) БУРДЭЛ МАЙНИНГ ХХК-С БАЯНГОЛ ЭХ ОРД 2022 ОН БОМТ ЗАРДЛЫН 50%		

 100900013406
 БОМТ

Тамга / Stamp:



Баталгаат гарын үсэг / Authorized signature:

 1. Б. Агашуу 2. 3.

Банкны тэмдэглэгээ / For bank use only:

ХУАжилтан №	Журнал №	Огноо	Гүйлгээний хураамж	Шилжүүлэгчийн биеийн байцаалтын төрөл №
392 (902)	816190018135	2022.05.06	1,000.00MNT	


 Он/YY: 2022.05.06
 Сар/ММ: 06
 Өдөр/DD: 06

Хүлээн авагчийн / Beneficiary's:


Банкны нэр / Bank name:	Дансны № / Account №:	Нэр (байгууллага эсвэл иргэн) / Name (organization or individual):
MOF (TREASURY FUND)	100900013406	БО нөхөн сэргээх баталгаа
Мөнгөн дүн тоогоор / Amount:	Мөнгөн дүн үсгээр / Amount in word:	Валют / Currency:
35,375,000.00	Гучин таван сая гурван зуун далан таван мянган төгрөг	MNT
Гүйлгээний утга, бусад тэмдэглэл / Details of payment:		Нууц код / Code:
БҮРДЭЛ МАЙНИНГ ХХК -С ИХ ТОХОЙРОЛ ОРД 2022ОНЫ БОМТ ЗАРДЛЫН 100%		

Шилжүүлэгчийн / Sender's:

Банкны нэр / Bank name:	Дансны № / Account №:	Нэр (байгууллага эсвэл иргэн) / Name (organization or individual):
TRANS BANK	90200172	АЗЗАЯА 902
Мөнгөн дүн тоогоор / Amount:	Валют / Currency:	Гүйлгээний төрөл / Transaction type:
35,375,000.00	MNT	Банк хооронд бэлэн мөнгө шилжүүлэх
Харилцагчийн тэмдэглэл / Customer note:		
100900013406 (35'375'000) БУРДЭЛ МАЙНИНГ ХХК-С ИХ ТОХОЙРОЛ ОРД 2022 ОН БОМТ ЗАРДЛЫН 100%		

 100900013406
 БОМТ

Тамга / Stamp:




Баталгаат гарын үсэг / Authorized signature:

 1. Б. Агашуу 2. 3.

Банкны тэмдэглэгээ / For bank use only:

ХУАжилтан №	Журнал №	Огноо	Гүйлгээний хураамж	Шилжүүлэгчийн биеийн байцаалтын төрөл №
392 (902)	816190018131	2022.05.06	1,000.00MNT	





ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2022 / Б-88
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Бүрдэл майнинг" ХХК , MV-007712
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : П.Энхбаяр, УНУАЗА-ны дарга
Сорьцын тоо, төрөл : 1, бохир ус
Сорьцыг авсан огноо : 2022.07.26
Сорьцын тодорхойлолт : Бохир усны сорьц
Шинжилгээний аргын стандарт : **MNS ISO 10523:2001, MNS 6836 :2020**
MNS ISO 6060:2001, MNS ISO 5815-1:2015
MNS ISO 7150-1:2006, MNS 4431:2005
MNS ISO 7890-3:2001, MNS ISO 6878:2001
Шинжилсэн огноо : 2022.08.01-08.10
Хуудасны тоо : 1 /1
Үр дүн : 1

Сорьцын авсан цэг	pH	Ж/б мг/л	XXX мг/л	NH ₄ -N мг/л	NO ₂ -N мг/л	NO ₃ -N мг/л	N _{нийт} мгN/л	P _{эрд} мг/л
Төв аймаг Заамар сум Их тохойрол уурхай Гол руу нийлж буй хаягдал ус	7.34	17	36.6	0.04	0.335	2.70	3.08	0.115
MNS4943:2015	6-9	30	50	-	-	-	15	1.5

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, XXX- Химийн Хэрэгцээт Хүчилтөрөгч

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер :

Хянаж баталгаажуулсан инженер :



Г.Нарансолонго

Ц.Мийдүв

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: **БҮРДЭЛ МАЙНИНГ ХХК**

ДЭЭЖИЙН
ТӨРӨЛ, ТОО

Цэвэршүүлсэн
бохир ус, 1

ЗАХИАЛГА №: 2022/1490

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2022.08.18

ШИНЖИЛСЭН ОГНОО: 2022.08.29

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: **хийгдээгүй**

ХУУДАСНЫ ТОО: 1

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна.
